



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/401

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар
өмчлүүлэх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 132 иргэнд 9.60 га газрыг хавсралт ёсоор өмчлүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчдөд, иргэний өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210532